



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2018.01.22, ДАВАА ~ №016 (815)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Ө.Энхтүвшин: Малчдаас татвар авах шаардлагатай

Мөнгөн дүнгээр тооцвол экспортоос 137 тэрбум төгрөгийн орлого олжээ. > 2

Сархдад самуурсан "цэцэг"

1992 хүн архинаас гаргах эмчилгээнд хамрагдсаны 339 нь эмэгтэйчүүд байжээ. > 5



■ АНУ-ын Ерөнхийлөгч Д.Трампын нэг жил
■ Нэг хүүхдийн бодлогыг халсан ч төрөлт нэмэгдсэнгүй

Ubinfo.mn сайт шилдэгт багтлаа

"Засгийн газрын мэдээ" сонины цахим хуудас Ubinfo.mn нь Монголын мэдээллийн шилдэг сайтуудын тавдугаарт бичигдлээ.

- Gogo.mn
- Xopom.com
- Ikon.mn
- Caak.mn
- Ubinfo.mn
- Zaluu.com
- News.mn
- Medee.mn
- Ubnew.info
- Olooo.mn

Эх сурвалж: Alexa.com ©

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Улсын дээд шүүх МАХН-ыг дотооддоо асуудлаа шийдэхийг зөвлөжээ.

Донорын тухай хуулийг шинэчлэн найруулж баталлаа.

Монгол, Америкийн улс төрийн ээлжит зөвлөлдөх уулзалт Улаанбаатар хотноо болов.

ЭДИЙН ЗАСАГ

Дэлхийн эдийн засгийн чуулган Швейцарийн Давос хотноо маргааш эхэлнэ.

АНУ хөдөлмөр эрхлэх жагсаалтаа Монгол Улсыг багтаалаа.

"Оюутолгой"-н дотоодод зарцуулсан мөнгөн хөрөнгө долоон тэрбум ам.доллар давлаа.

НИЙГЭМ

Зудын эрсдэлтэй байгаа аймгуудад түргэн тусламжийн машин өгөв.

Нийслэл бүтээн байгуулалтын ажлаа дөрөвдүгээр сарын 1-нээс эхлүүлнэ.

Ш.Баярсайхан өвлийн олимпын бамбарыг буухиалсан анхны монгол хүн боллоо.

ДЭЛХИЙ

АНУ төсвөө баталж чадаагүй тул Цагаан ордон утасны дуудлагад хариу өгөхгүй байна.

Туркийн арми Сирийн Африн хотын орчимд цэргийн ажиллагаа явуулж эхэлжээ.

Чилийн хойд нутагт 6.3 магнитудын хүчтэй газар хөдлөлт боллоо.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2018.01.22

-27° -37°

ҮҮЛШИНЭ

ЦАГ АГААРЫН ДЭГЭРЭЖИЙГ МЭДЭЭЛЛИЙГ 8 ДУГААР НУУРГУУС УНШИНА УУ



86580001029112 00815

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Бизнесийн боломжоос хумслах төр



Шийдвэр гаргагчид улс орны төсөв, санхүүгийн байдал хүнд байна хэмээн байнга "уйлагнаж", иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийг өсгөлгүй өдий хүрсэн атлаа төрийн нэр дээрх эд хөрөнгийг 1.8 дахин өсгөжээ. ▶12

С.Батсайхан / ЗГМ ©

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Хохирогчоо намнадаг хүчирхийлэгчид нь бид

Б.Баярмаа @bayarmaaZGM

Өвлийн хүйтэн жавраас илүү хүний мөсөд хайруулж, жинддэг цаг иржээ. Хүний олон хүнээ барьж "идсэн" олон түүхийг сонсоод цөвүүн цагийн гэрч болж буйдаа харамсав.

Нэгэн сумын хэсгийн байцаагчаар ирээд удаагүй шинэхэн цагдаа ангийнхаа охиныг хүчирхийлсэн залуугийн аавыг дууджээ. Хүүг нь муу хэрэгт холбогдсоныг халган байж хэлэхэд аав нь "Энэ чинь хонины бэлчээрт байнга л

болдог хэрэг. Ямар сүртэй юм бэ" гэж үл тоомсорлосон байдаг. Хүчирхийлэл нийгмийн аль ч цаг үед байсан нь үнэн.

Гэхдээ байх ёстой, хэн нэгэн үүний золиос болох нь энгийн үзэгдэл гэсэн үг биш. Харин ч хүнлэг, энэрэнгүй, ардчилсан нийгэмд бидний хувьд хамгийн том дайсан бол хүчирхийлэл. Гэтэл ардчилалд хөл тавьсан 20 гаруй жилд эмэгтэйчүүдийг бусдын хүчинд автахыг байдал зүйл мэт хардаг бидний гажиг сэтгэлгээ улам л хорон болсоор байна.

▶3

АРВАН САЯ ТӨГРӨГИЙН ШАГНАЛТАЙ ЯРУУ НАЙРГИЙН НААДАМ БОЛНО



Оюуны боловсролд үнэлж баршгүй хувь нэмрээ оруулсан эх оронч, нэрт яруу найрагчдын алдрыг мөнхлөх, залуу хойч үедээ эх оронч үзлийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Сод Монгол Групп" ХХК-аас яруу найрагч, зохиолчдын дунд хамгийн өндөр шагнальтай яруу найргийн наадмыг энэ жилээс эхлэн зохион байгуулахаар боллоо.

Энэхүү наадам нь Монгол Улсын төрийн соёрхолт Сүхбаатарын одонт, Соёлын гавьяат зүтгэлтэн, нэрт зохиолч, яруу найрагч Зундуйн Дорж, Монгол Улсын Төрийн шагналт, төр нийгмийн нэрт зүтгэлтэн, нэрт зохиолч, яруу найрагч Очирбатын Дашбалбар агсны нэрэмжит бөгөөд энэ сарын 26 нд болох юм байна.

Зохиолч, яруу найрагч З.Дорж, О.Дашбалбар агсны нэрэмжит яруу найргийн наадмын тэргүүн байрын шагнал 10 сая төгрөг, хоёрдугаар байр таван сая төгрөг, гуравдугаар байр ном хэвлүүлэх эрхийн эзэн болно.

Хамгийн өндөр шагналын сантай энэхүү яруу найргийн наадмын эхний үе шатанд зохиолчид:

- Эх дагина Дондогдуламын үйл хэрэг,
- Эх дагина Дондогдуламын эрдэм чадал,
- Эх дагина Дондогдуламын нэрээр нэрлэсэн анагаах увидас нь олны дунд түгэн гайхагдсан Дондогдулам рашааны тухай зэрэг сэдвийн хүрээнд naadam@sodmongolgroup.com и-мэйл хаягаар 01 дүгээр сарын 19-ний өдрийн дотор бүтээлээ илгээх юм байна.

Нэгдүгээр шатанд ирсэн шүлэг, яруу найргийг мэргэжлийн шүүгчид шүүж шалгарсан бүтээлийн эзэд II, III шатанд эх оронч сэдвийн хүрээнд өрсөлдөх юм байна.

ЯРУУ НАЙРГИЙН НААДМЫН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ АВАХ УТАС: 99096867, 99104180

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх танаа

МУИС-ИЙН БАГШ НАРЫН ӨРГӨХ БИЧИГ

2018 оны 1 сарын 19 өдөр

Монгол Улсын хөгжлийн үндсэн тулгууруудын нэгд чанартай дээд боловсрол байна гэдэг нь маргашгүй бөгөөд Монгол Улсын Их Сургууль (МУИС) энэхүү үйл хэрэгт эн тэргүүнд манлайлан оролцох учиртай. Гэтэл МУИС-ийн өнөөгийн байдал ёс зүйгүй, их сургуулийн сургалт, судалгааны талаар мэдлэг, чадваргүй хүмүүсийг захирлын үүрэг гүйцэтгэгч, удирдах албан тушаалд томилсноос үүдэн замбараагүйгэл эцэстээ хүрч, багш, ажилтан, оюутнууд бухимдаж байна. Шийдэл хүлээж байгаа доорх ноцтой мэдээллүүдийг шалгаж,

асуудлыг шийдвэрлэн Монгол Улсын Их Сургуулийг аварна гэдэгт найдаж байна.

МУИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгч Я.Төмөрбаатар нь 75 жилийн түүхтэй эрдмийн хамт олныг удирдах мэдлэг боловсрол, туршлага, цар хүрээ, ёс суртахууны төдийгүй хувь хүн талаасаа МУИС-д гологдож байна. Өнгөрсөн хугацаанд МУИС-ийн ректороор салбартаа үнэлэгдэн хүлээн зөвшөөрөгдсөн, гадаад дотоодод нэр хүндтэй, эрдмийн зэрэг цолтой, ёс суртахуун төгөлдөр эрдэмтнийг томилдог байсан. Гэтэл дээрх шаардлагад үл тохирох хүнийг МУИС-ийн удирдлагад МАН-аас томилсон явдал нь эрдмийн хамт олныг гонсойлгосон хэдий ч бүтэн нэг жилийн хугацаанд бид

үүрэг гүйцэтгэгч Я.Төмөрбаатар болмож өгч, хүлээцтэй хандаж ажилласан боловч МУИС-ийн нөхцөл байдлыг улам дордуулсан.

Үүрэг гүйцэтгэгч Я.Төмөрбаатар Монгол Улсын ууган их сургууль болох МУИС-ийг 2024 он гэхэд Судалгааны их сургууль болгох, Азийн шилдэг 100 сургуульд багтаах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хөтөлбөрүүдийг олон улсад магадлан итгэмжлүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтийг бүрэн дэмжихүйц сургалтын орчныг бүрэлдүүлэх зэрэг олон ажлыг хийнэ гэж тунхагласан боловч дорвитойхон ажил огт хийсэнгүй.

▶4

MSE ALL

1174.99
0.1%

АЛТ

1331.84
0.36%

ЗЭС

7041
0.49%

10-ЧИНГИС БОНД

100.92
0.04%

ГЭРЭГЭ БОНД

102.83
0.03%

АМ.ДОЛЛАР

2423.57

ЮАНЬ

378.55

РУБЛЬ

42.81

Улс төр

ЗАСГИЙН ГАЗАР

15-39 насныхныг В, С вирусийн шинжилгээнд хамруулна

Б.Энхжаргал
@enkhjirgZGM

“Элэг бүтэн монгол” хөтөлбөрийн хүрээнд элэгний В, С вирусийн шинжилгээний зардалд 6.3 тэрбум төгрөгийг зарцуулсан бол, С вирусийн эмчилгээнд 9.6 тэрбумыг зориулжээ.



Б.Ганбаяр / ЗГМӨ

Ө.Энхтүвшин: Малчдаас татвар авах шаардлагатай

Энэ хүрээнд гепатитийн В вирусийн эсрэг сайн дурын дархлаажуулалтад давхардсан тоогоор 90 гаруй мянган хүнийг хамруулсан аж. Мөн эрүүл мэндийн даатгалын сангаас С вирусийн таван нэрийн эмийг хайрцаг тутамд нь 210 мянган төгрөгөөр, нэг курс эмчилгээний зардлыг үргэлжлэх хугацаанаас хамааран 630-1 сая 260 мянган төгрөгөөр хямдруулан олгож байгааг Ерөнхий сайд У.Хүрэлсүх баасан гарагт болсон Нэгдсэн чуулганы үеэр мэдэгдлээ. Эрүүл мэндийн сайдын төсөв энэ онд 760.3 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оныхоос 9.5 хувиар нэмэгдсэн аж. Монголд хийгдэж байгаа өндөр өртөгтэй мээ засалд зарцуулах төсвийг энэ онд 44.6 тэрбум төгрөгт хүргэж, 17.4 хувиар нэмжээ. Тодруулбал,

эрхтэн шилжүүлэх мээ засалд шаардагдах төсвийг дөрөв дахин нэмж 2.8 тэрбум төгрөгт хүргэсэн байна. Түүнчлэн энэ оноос 15-39 насны хүмүүсийг эрт илрүүлэг үзлэгт хамруулах, урьдчилан сэргийлэх үзлэгт 10.2 тэрбум төгрөг төсөвлөсөн аж. Мөн элэгний С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээнд 4.9 тэрбум төгрөг, С вирусийн эмчилгээний эмийн хөнгөлөлтөд 18.4 тэрбум төгрөгийг Эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэхээр батлаад байгааг мэдээллээ. Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэд гепатитийн В, С вирусийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдаж чаддаггүй. Тэгвэл ийм иргэдийг даатгалд хамруулах ажлыг Засгийн газраас идэвхжүүлнэ хэмээн мэдээллээ.

МАХНЫ ЭКСПОРТООС 137 ТЭРБУМ ТӨГРӨГ ОЛЖЭЭ

Ерөнхий сайдын мэдээллийн дараа Шадар сайд Ө.Энхтүвшин өвөлжилтийн нөхцөл байдлын талаар асуулгын хариуг өгсөн юм. Одоогоор улсын хэмжээнд нийт нутгийн 80 гаруй хувьд цасан бүрхүүл тогтож, 100 гаруй суманд өвөлжилт хүндэрч болзошгүй байгаа аж. Энэ жил улсын хэмжээнд нийт 160.9 мянган малчин өрхөд 66.6 сая, хонин толгойд шилжүүлснээр 106.9 сая толгой малыг өвөлжүүлэх бэлтгэлийг хийсэн. Харин өвөл, хаврын бэлчээрийн даацын судалгаагаар нийт нутгийн 25 хувь нь хүрэлцээтэй, 30 хувь нь 1-3 дахин хэтэрсэн, 10 хувь нь 3-5 дахин хэтэрсэн, 30 хувь олон дахин хэтэрсэн гэсэн дүгнэлт гарсан байна.

Өвөлжилтийг гарз, хохирол багатай давахын тулд Засгийн газраас хийсэн ажлуудын талаар мэдээлэл өгөхдөө Ө.Энхтүвшин “Цаашид малыг бэлчээрийн даацад тааруулахын тулд малаа эдийн засгийн эргэлтэд оруулах, махыг нь экспортод гаргах, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, тариалалтыг нэмэгдүүлэх шаардлага байна. Мөн малын хөлийн татвар ногдуулдаг болох шаардлагатай” гэв. Өнгөрсөн оны эцсийн байдлаар БНХАУ-д адууны мах экспортлох эрхтэй найм, хонь ямаа, үхрийн мах экспортлох эрхтэй зургаа, дулааны аргаар боловсруулсан мах экспортлох эрхтэй тав, нядалгааны эрхтэй найм, ОХУ-д мах махан бүтээгдэхүүн экспортлох эрх бүхий магадлан итгэмжлэгдсэн

29 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулжээ. Мөн Вьетнам улсад дулааны аргаар боловсруулсан хонь, ямаа, үхрийн мах экспортлох эрх бүхий магадлан итгэмжлэгдсэн дөрвөн компани байгаа аж. Эдгээр компани ОХУ-д 560 тонн үхрийн, БНХАУ, ОХУ, Казакстан, Япон улсад нийт 24.9 мянган тонн адууны, Иран, Катар улсад 2.45 мянган тонн хонь, ямааны мах экспортложээ. Мөнгөн дүнгээр тооцвол экспортоос 137 тэрбум төгрөгийн орлого олжээ. Энэ нь өмнөх таван жилийн дундажтай харьцуулахад махны экспортын тоо, хэмжээ долоо дахин, өмнөх онтой харьцуулахад гурав дахин нэмэгдсэн үзүүлэлт юм. Харин дулааны аргаар боловсруулсан нөөжилсөн мах, махан бүтээгдэхүүн хоёр мянган тонныг экспортложээ. [ЗГМ]

ТОВЧХОН

» **ЕРӨНХИЙЛӨГЧ**
Шанхайн хамтын ажиллагааны байгууллагуудын уулзалтад Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга оролцох аж. Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар “Бид Монгол Улсын Ерөнхийлөгчийг ШХАБ-ын уулзалтад оролцуулахаар бэлтгэл хангаж байна” хэмээн мэдэгдсэн юм.

» **НАМУУД**
МАХН-ын даргаар О.Баасанхүүг сонгосныг бүртгэх эсэх асуудлаар болсон УДШ-ийн шийдвэр гарчээ. Дээд шүүх УИХ-ын гишүүн О.Баасанхүүг МАХН-ын даргаар бүртгэхээс татгалзсан байна.

» ТОО

27

Мянган төгрөг. Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэврийг ирэх хоёрдугаар сарын нэгний өдрөөс эхлэн 27 мянган төгрөгөөр нэмэгдүүлэв. Ингэснээр 393 орчим мянган иргэний тэтгэвэр нэмэгдэж байна.

» УУЛЗАЛТ

Монгол Улсын Гадаад харилцааны яам, АНУ-ын Төрийн департамент хоорондын ХII үйлдлийн зөвлөлдөх уулзалт Улаанбаатар хотноо боллоо. Уулзалтаар АНУ-ын Мянганы сорилтын корпорацитай Хоёр дахь компакт гэрээ байгуулах бэлтгэлийг хангах, “H2” визийн хөтөлбөрт хамрагдах ажлыг нөөжилсөн мах, махан бүтээгдэхүүн хоёр мянган тонныг арилцав.

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» INFO@ZASAG.CO

Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

[ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Ерөнхий эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРЛОО

Зөвлөх
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦИ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Даваагтох
Утас: 99901637

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба
Эдитор Б.Баяртгогтох
Утас: 99901532

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Э.Энхбаатар
Утас: 99903578

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, I хороо, Энхтайвны өргөн чөлөө, “Бло Скай тауэр” 407 тоот Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131, Факс: 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР

ubinfo.mn

Дугаарын удирдагч
Б.Баяртгогтох



М.Энхболд: Монгол Улсын хувьд олон улс, бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох нь Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх нэг чухал арга хэрэгсэл юм

Ази-Номхон далайн орнуудын парламентын чуулганы 26 дугаар хуралдааны “Бүс нутгийн хөгжлийн хамтын ажиллагаа” сэдэвт САЛБАР хуралдаанд УЛСЫН ИХ ХУРЛЫН дарга М.Энхболдын хэлсэн үг
Ханой хот, 2018 оны нэгдүгээр сарын 20

Хурлын дарга аа, Эрхэм хүндэт Үндэсний Ассамблейн дарга аа, Эрхэм парламентчид аа, Хатагтай, ноёд оо,

Энэхүү хуралдааныг өндөр түвшинд зохион байгуулж буй БНСВУ-ын Үндэсний Ассамблей болон хурлын төлөөлөгчдийг найрсгаар хүлээн авсан үзэсгэлэнт Ханой хотын оршин суугчдад талархал илэрхийлнэ.

Дэлхий нийтээр “Тогтвортой хөгжил-2030” хөтөлбөр, Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Парисын гэрээ зэрэг томоохон зорилтуудыг хэрэгжүүлж байгаа энэ үед манай гаргийн хамгийн том, эрчимтэй хөгжиж буй бүс нутаг болох Ази, Номхон далайн орнуудын парламентчид “Бүс нутгийн хөгжлийн хамтын ажиллагаа”-ны сэдвийг хэлэлцэж байгаа нь цаг үеэ олон явдал юм.

Дэлхий нийтийн хөгжлийн зорилтуудыг үндэсний түвшинд хэрэгжүүлэх бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөгжлийн хамтын ажиллагааны эх үүсвэр, боломжуудыг зохистой ашиглах, санхүүжилтийн арга, хэлбэрүүдийг дэмжихэд үндэсний парламент чухал үүрэг гүйцэтгэх учиртай.

Хурлын дарга аа, Монгол Улсын Их Хурал “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” баримт бичгийг 2016 оны 2 дугаар сард баталж, үндэсний



түвшний зорилтуудаа анхлан тодорхойлсон улсуудын нэг болсон. 2030 он гэхэд Монгол Улс ардчилсан засаглалаа бэхжүүлж, экологийн тэнцвэрт байдлыг ханган, ядуурлын бүх хэлбэрийг устгаж, дээд эрэмбийн дундаж орлоготой улс орны эгнээнд шилжих зорилт дэвшүүлсэн юм. Манай Засгийн газраас Ази, Номхон далайн орнуудын парламентчид үзэл баримтлалыг дунд болон богино хугацаанд үе шаттай хэрэгжүүлэх бодлого баримталж байна. Өдгөө тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх бүхий л механизмьг цогцоор нь тусгасан төлөвлөгөөний матриц боловсруулж байна. Хөгжлийн санхүүжилтийг бүрдүүлэхэд улсын төсвөөс гадна хөрөнгө оруулагчдын оролцоог хангах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг дэмжихэд онцгой анхаарч байгаа юм.

Хурлын дарга аа, Зүүн хойд Азид оршдог, далайд гарцгүй манай улсын хувьд олон улс, бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох нь Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх нэг чухал арга хэрэгсэл юм. Тиймээс манай улс АСЕАН-ы Бүсийн чуулга уулзалт, Ази-Европын уулзалт, Азид хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх зэрэг хурал, чуулганы үйл ажиллагаанд идэвхтэй оролцож ирсэн. Мөн АСЕАН-ы яриа хэлэлцээний түнш болох эрмэлзэлтэй байдаг. Түүнчлэн Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт нэгдэх судалгаа хийж, хуулийн үзэл баримтлалыг боловсруулж байна. Зүүн хойд Азийн яриа хэлэлцээний механизмын хөгжилд хувь нэмрээ оруулахын тулд 2013 онд “Улаанбаатарын яриа хэлэлцээ”-г санаачилж, жил бүр хуралдааныг зохион байгуулж байгаа. Өдгөө бүс нутгийн аюулгүй байдал, эрчим хүч, дэд бүтцийн сүлжээ, ногоон хөгжил, хамтын ажиллагааны боломж зэргийг хэлэлцдэг, дэд бүсийн бүх улсын оролцоог хангасан нээлттэй механизм болон төлөвшиж байна.

2016 оны зургадугаар сард Ташкент хотноо болсон Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Төрийн тэргүүн нарын уулзалтын үеэр “Монгол-Орос-Хятад”-ын “Эдийн засгийн коридор” хөтөлбөрийг баталсан. Монголын “Хөгжлийн зам”, Хятадын “Торгоны замын эдийн засгийн бүс”, ОХУ-ын Евразийн эдийн засгийн холбоог уялдуулсан уг хөтөлбөрт гурван улсын хамтын ажиллагааны олон чухал зорилт туссан. Тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх асуудал энд гол байр суурийг эзэлж, түүнийг дагуулан чөлөөт бүс байгуулах, эко аялал жуулчлалын маршрут бий болгохоор төлөвлөж байна. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн тэргүүлэх салбарын нэг нь аялал жуулчлал юм. Тиймээс Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг бүс нутгийн хэмжээнд дээшлүүлж, эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, үр өгөөжийг нэмэгдүүлэхээр тусгасан. Аялал жуулчлалын нэр төрлийг нэмэх, дэд бүтцийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт татах, олон улсын

сүлжээнд нэгдэх, сайн туршлага, шилдэг стандартыг нэвтрүүлэх зэрэг чиглэлээр бүс нутгийн орнуудтай хамтран ажиллах сонирхол бидэнд байгааг сонордуулъя.

Хурлын дарга аа, Ази, Номхон далайн бүс бол гамшигт хамгийн өртөмтгий бүс нутгийн нэг. Энэ эрсдэлд нөлөөлж буй хүчин зүйлийн нэг нь байгаль орчны өөрчлөлт, цаг уурын дулаарал юм.

Байгаль, цаг уурын эрс тэс нөхцөлтэй, хөдөө аж ахуй, уул уурхайгаас ихээхэн хамааралтай эдийн засаг бүхий манай улсад цөлжилт, хөрсний доройтол, ой хээрийн түймэр зэрэг үзэгдлийн хамрах хүрээ, давтамж нэмэгдэж байна. Монгол Улс Парисын гэрээний дагуу 2030 он гэхэд хүлэмжийн хийн аялалын түвшинг 14 хувь бууруулах зорилт дэвшүүлж, түүндээ эрхэм зорилго чармайж байна. Дотооддоо экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгалийн баялгийн зохистой ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт, улмаар ногоон эдийн засгийг дэмжих эрх зүйн шинэ орчин бүрдүүлэхээр ажиллаж байна.

Хурлын дарга аа, Энэ завшааныг ашиглан манай улс ирэх долдугаар сарын 16-19-нд НҮБ-ын дэмжлэгээр Гамшигийн эрсдэлийг бууруулах асуудал эрхэлсэн Азийн Сайд нарын хоёрдугаар хурлыг Улаанбаатар хотноо зохион байгуулах гэж байгааг Та бүхэнд дуулгая. Гамшигийн эрсдэлийг даван туулах чадвартай, тогтвортой хөгжилтэй нийгмийг цогцлоохын төлөө бүсийн түвшний зөвлөлдөх механизмыг бэхжүүлэх, сайн туршлагыг хуваалцах зорилготой уг хуралд Та бүхнийг өргөнөөр оролцож, хувь нэмрээ оруулна гэдэгт итгэж байна. **Анхаарал хандуулсанд баярлалаа.**

Нийтлэлчийн булан

Хохирогчоо намнадаг хүчирхийлэгчид нь бид

Монголд 10 хүчирхийлэгчийн нэгийг нь л мэдээлдэг

Огт танихгүй атлаа социал сувгаар дайрч давшилна, харин таньдаг нэгэн нь хохирогчийн талд орвол өөрөө буруутан болчих юм шиг санаж зайгаа авна.

Хуулийнхан хүртэл хэргийг мэдээлэхдээ хохирогчийн талаар тэр сумын, тийм мэргэжилтэй, гэдэн настай гээд овог, нэрээс бусад бараг бүх хувийн мэдээлэлд нь эрээ цээргүй халддаг бол хэвлэлийнхэн үүнийг аманд орсон шар тос мэт шүүрэн авч, улам дэвэргэдэг. Гэтэл хөдөө орон нутагт хүн ам цөөн, нэгийгээ үе удмаар нь мэддэг тул хохирогч хэн бэ гэдгийг таахад тун амархан. Хамгийн харамсалтай нь тухайн хүнийг гэмт хэрэгт өртсөн гэдгийг мэдмэгцээ өөрийн муугаас, арчаагүйгээс, санамсар болгоомжгүйгээсээ болж эмгэнэлтэй явдлын золиос боллоо гэгцээдэг. Мөнгөө хулгайд алдсан хүнийг "Чи яагаад оройн цагаар ганцаараа явсан юм бэ" гэж хэн ч буруутгадаггүй. Тэгсэн атлаа хүчирхийлэлд өртсөн хөөрхий нэгийг "Задгай хувцасласан, эрчүүдтэй нэр холбогддог, шөнө дөлөөр ганцаараа явсан" гэх зэргээр чичилж эхэлнэ. Харин дараа дараагийнх нь үүнээс ч дор үгээр давшилж гарна. Байцаагч нь хүртэл "Чи өөрөөсөө л болсон юм биш үү" гээд сэтгэл зүйн дайралт хийгээд сууж байдгийг цөөнгүй хохирогчоос сонсож байлаа. Энэ мэт нийгмийн давхар дарамтаас айсан хохирогчид нүдний булай, түмний шившиг болж байхаас чимээгүй явсан

нь дээр гээд зарим хэргийг хав дардаг гэдгийг мэргэжлийнхэн хэлж байна. Ийнхүү өөрийнх нь нууц байх ёстой мэдээлэл ил болсноос хохирогч амиа хорлохоос өөр сонголт үлддэггүй аж.

Монголд хүчирхийллийн 10 хохирогчийн ес нь бусдад хэлдэггүй, мэдээлдэггүй гэсэн судалгаа бий. Өөрөөр хэлбэл, 10 хохирогчийн ес нь нийгмийн давхар дарамтаас дасан зохицож амьдарсаар байна. Зориг гарган хуулийн байгууллагад хандсан зарим нь бусдын дарамт, гадуурхлаас айсандаа гомдлоо буцаадаг бол, зарим нь худал мэдүүлдэг аж. Гэтэл үүний цаана ахин гэмт хэрэг үйлдэхээ буцахгүй болсон хэрэгтэн давхар, амтшиж байдаг нь ойлгомжтой.

● **Хуулийн байгууллагад хандсан зарим нь бусдын дарамт, гадуурхлаас айсандаа гомдлоо буцаадаг аж.**

● **Насандаа мартамгүй бие, сэтгэлийн шархтай хохирогчийг бүү "намна", сохроор бүү ялла.**

● **Өнгөрсөн хоёр жилд 213 хүүхэд бэлгийн хүчирхийллийн золиос болсон байна. Дээрх тохиолдлуудын 26.3 хувь нь олон удаа давтан үйлдэгджээ.**

Манай улсад өнгөрсөн хоёр жилд 13 хүртэлх насны 213 хүүхэд бэлгийн хүчирхийллийн золиос болсон байна. 2016 онд 91 хүүхэд, өнгөрсөн онд 122 хүүхэд



Эмэгтэйчүүдийг бусдын хүчинд автахыг байдаг л зүйл мэт хардаг бидний гажиг сэтгэлгээ улам л хорон болсоор.

Б.Ганбаяр / ЗГМӨ

холбогдсон гэдэг нь анзаарахгүй орхиж боломгүй тоо. Дээрх тохиолдлуудын 26.3 хувь нь давтан үйлдэгдсэн бөгөөд үүний 30.4 хувь нь 3-7 жилийн

турш давтагдсан гэх статистик байна. Энэ бүхэн нөгөө л бидний хохирогчийг буруутгадаг муйхар үзлээс улбаатай гай. Хэрэв бид хохирсон хүнийг

өмгөөлдөг, цэвдэг сэтгэлээр гадуурхдаггүй байсан бол тэд зовлонгоо бяцхан нуруундаа муйхар үзлээс улбаатай гай. Хэрэв бид хохирсон хүнийг

Хүчирхийлэлд өртсөн түүхээ ярьсан Г.Номуундарь охиныг, түүний гэр бүлийнхнийг энэ нийгэм шүүхийн тогтоолгүйгээр хэрхэн яллаж буйг бид нүдээрээ харж байна. Худалч, сэтгэцийн өвчтэй, баян айлын эрх охин гээд түүнийг гишгэх газаргүй болтол муулж, чичилсэн яриа сэтгэгдэл хаа сайгүй хөвөрнө. Үүнийг овжиноор ашигласан хэдэн залуу хэргээс мултрахаар танил талаараа хөөцөлдөж, эцэст нь шүүх, цагдаад ч нөлөөлөхөөр улайрч буй нь мэдээж.

Уг хэрэг яаж ч шийдэгдсэн байсан хэдэн жилийн дараа олон нийт хэрэгтний талаар мартаж, харин хохирогчийн талаарх бараан дурсамж үлдсэн байх нь гарцаагүй. Энэ бол хуучин сэтгэлгээндээ баглагдсан монголчуудын муухай араншин. Гаднын орнуудад ийм байдалд орсон хүнийг харанхуй дурсамжийг нь сэдэрэхгүйн тулд бүхий л талаар дэмжиж, хамгаалдаг. Бэр, хань ижлээ болгож байгаа хүмүүс хүртэл бараан дурсамжийг нь мартуулж амьдрах ёстой гэсэн итгэл үнэмшлээр хохирогчийг хүлээж авдаг. Сэтгэл санааг нь дээрдүүлэх, амьдралд итгэх итгэлийг нь сэргээхийн тулд мэргэжлийн сэтгэл зүйчид тусалж, мэдээллийг нь чандлан нууцалдаг. Харин манайд эсрэгээрээ. Хохирогчдод нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлдэггүй хэрнээ дээрээс нь нэмж нийгмээрээ дарамталдаг жишиг бүр ужгирлаа.

Бид хүнлэг, энэрэнгүй, ардчилсан нийгэм гэж ярих дуртай ч хувиа бодсон, бусдын мууд дуртай, хүйтэн сэтгэлтнүүд болж байна. Ардчилсан нийгмийн хэмжээ, хязгаарыг үл ойшоож, анархизмдаа живж байх шиг. Бие сэтгэлээр хохирсон хүнийг халуун дулаан сэтгэл л эдгээдэг. Харин манай нийгэмд ийм сэтгэхүй алга. Хэн ч гэмт хэргийн золиос болж болзошгүй. Бусдыг харгисаар буруутгаж, дайрч давшилдаг хүмүүс нэг цагт тань руу, таны ойр дотныхон руу хорон үгээ чиглүүлж ч мэдэх. Тиймээс насандаа мартамгүй бие, сэтгэлийн шархтай хохирогчийг бүү "намна", сохроор бүү ялла. [ЗГМӨ]

С.ЦОГТБАЯР ЗУРЖ БАЙНА



©2018 SATSO & ZGM

Сурталчилгаа

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД У.ХҮРЭЛСҮХ ТАНАА

МУИС-ИЙН БАГШ НАРЫН ӨРГӨХ БИЧИГ

1. МУИС-Д ШУДАРГА ЁС, ИЛ ТОД БАЙДАЛ АЛДАГДАЖ ЁС ЗҮЙГҮЙ ҮЙЛДЭЛ ХЭРЭЭС ХЭТЭРЧ БАЙНА

1.1 Тэрбээр удирдлагын оновчтой, **үр ашигтай** бүтцээр ажиллахын оронд МУИС-ийн бүтцэд урьд өмнө огт байгаагүй газар, алба, хэлтсүүдийг шинээр байгуулж, зөвхөн 2017 онд **47 хүнийг** шинээр ажилд авсны дээр (Хавсралт 1) зарим албан тушаалуудад хуйвалдааны шинжтэй томилгоо хийсэн. МУИС-ийн Багш нарын холбооны тэргүүн П.Лхамсүрэнг албан тушаалаар шагнаан, урвуулсан нь багш нарын шударга дуу хоолой, шүүмжлэлийг боомилох гэсэн увайгүй, явуургүй оролдлого болсон.

1.2 Я.Төмөрбаатарын шинээр бий болгосон албан тушаалд томилогдсон Дотоод хамтын ажиллагаа, олон нийттэй харилцах хэлтсийн дарга П.Лхамсүрэн нь БСШУС-ын сайдын 2017 оны есдүгээр сарын 29-ны өдрийн А/207 “*Докторын ажил хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай*” тушаалаар **хүчингүй** болсон **Эрдмийн Их Сургуулийн Хүмүүнлэгийн** докторын ажил хамгаалуулах зөвлөл дээр 2017 оны аравдугаар сарын 5-нд **Бизнесийн удирдлагын ухаанаар** докторын зэрэг хамгаалсан нь Монгол Улсын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн үйлдэл болсон талаарх мэдээлэл олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр цацагдсан. (Хавсралт 2)

Энэхүү хууль бус үйлдлийн талаар нэг биш удаа сургуулийн удирдлага, холбогдох яамд мэдэгдсээр атал ямар ч арга хэмжээ аваагүй, үл тоомсорлон байгаа нь МУИС болон МУИС-ийн үе үеийн эрдэмтэн профессоруудын нэр хүндийг олон нийтэд илтэд унагаж, багш ажилтнуудын удирдлагадаа итгэх итгэл, ёс зүйн хэм хэмжээг уламдаа гишгэсэн хариуцлагагүй үйлдэл болж байна.

Я.Төмөрбаатарын томилсон П.Лхамсүрэн нь Хэнтий аймагт 2018 оны нэгдүгээр сард сургалт явуулах нэрийдлээр багш нарыг **УИХ-ын гишүүн Д.Гантулгын** нэрийг цэвэрлэх ажилд шууд бусаар оролцуулж багш нарын эгдүүцлийг хүргэлээ.

1.3 Я.Төмөрбаатар нь үүрэг гүйцэтгэгчээр ирснээсээ хойш захиргааны бүтцийг хэт ихээр данхайлгасан, дэд захирлууд нь тус, тусдаа үүдэндээ туслахуудтай болж, үр ашиггүй зардлыг эрс нэмэгдүүлсэн. Үүний зэрэгцээ, шинээр буй болгосон орон тоог их, дээд сургуулийн сургалт, үйл ажиллагааны талаар ойлголт, мэдлэг, туршлагагүй, танил

тал, намын гэх хүмүүсээр дүүргэсэн нь МУИС-ийн эрдэм шинжилгээ, сургалтын хэвийн үйл ажиллагааг алдагдуулж, чанарыг эрс доголдуулж байна.

1.4 Я.Төмөрбаатарын МУИС-д ирэхдээ авч ирсэн намын томилгоотой гэх **Винтовын Алтансүхийг** МУИС-ийн Хангамж үйлчилгээний газрыг шинээр байгуулан даргаар нь, санхүүгийн мэргэжлийн бус **Д.Отгонбаатарыг** Санхүү, эдийн засгийн газрын дарга хэмээх шинэ орон тоо гарган томилсон нь бидэнд хууль бус далд үйлдлүүд явагдаж байгаа гэсэн хардлагыг шууд төрүүлж байна.

1.5 МУИС-тай **санхүүгийн эрх ашгийн зөрчилтэй** (хуучнаар ХУДС-ийн захирал асан, одоогийн ЗГХЭГ-ын боловсрол хариуцсан референт **Б.Батсайхантай** хамааралтай санхүүгийн хэрэг) **Д.Оюундэлгэрийг** байгууллагын дотоод нууц, хувь хүний нууцыг хариуцдаг хүний нөөцийн мэргэжилтнээр томилон МУИС-ийн болон багш ажилтнуудын эрх ашгийг зөрчиж байна.

1.6 “МУИС-ийн шагнал урамшууллын нийтлэг журам”-д заасан **6-аас дээш жил** ажилласан багш, ажилтнуудад олгодог “Хүндэт жуух бичиг”-ээр нэг жил хүрэхгүй хугацаанд ажилласан өөрийн хүн **В.Алтансүхийг** Я.Төмөрбаатар нь шагнаж МУИС-ийн дүрэм журмыг илтэд зөрчиж багш ажилтны эрхэмлэдэг шагналыг үнэ цэнгүй болгосон. (Хавсралт 3)

1.7 Тэрбээр хамт олноос хууль бус зүйлээ нуухын тулд доод албан тушаалтнуудтайгаа **нууцлалын гэрээ** гэгчийг байгуулна хэмээн МУИС-д урьд өмнө болж байгаагүй сүрдүүлэг явуулж, ажилтнуудад **ажлын байрны дарамтыг** үзүүлэх болсон байна. Энэ нь МУИС-д мэдээллийн ил тод байдлыг үгүй хийж буй Я.Төмөрбаатарын улс төрийн арга болно.

1.8 2013-2016 онд МУИС-ийн удирдлагын багт МУИС-ийн сургалтын нэгдсэн албаны даргаар ажилласан **Ч.Ундрам** нь албан үүргээ урвуулан ашиглаж журам зөрчин өөртөө дэд профессор цол олгуулсан, мөн төгсөх шаардлага хангаагүй оюутан төгсгөхөд эрх үүргийнхээ хүрээнд хариуцлагагүй ажиллан хууль бус үйлдэл хийж (Хавсралт 5: АТГ-ын 2017 оны арваннэгдүгээр сарын 10-ны 05-8107 албан тоотгоор иргэн Д.Бадамцэцэгт ирүүлсэн гомдлын хариу) хамт олондоо нэр хүндгүй болсон хүнийг үүрэг гүйцэтгэгчээр ирсэн Я.Төмөрбаатар нь ерөнхий сайд асан **Ж.Эрдэнэбатын** захиалгат хүн хэмээн удирдлагын багтаа

авч МУИС-ийн дэд захирал болгон хамтран ажиллаж байгаа нь МУИС-ийн эрдмийн хамт олныг үл хүндэтгэсэн, ёс зүйгүй үйлдэл болсон.

1.9 МУИС-ийн үүрэг гүйцэтгэгч Я.Төмөрбаатар нь **өөрийгөө** намын томилгоогоор ирсэн хүн, намын дарга **М.Энхболдын** хүн, одоо Ерөнхий сайд **У.Хүрэлсүхийн** хүн, сайд **Ц.Цогзолмаагийн** нутгийн хүн гэх зэрэг мессеж тараан, захирлаар жинхлүүлнэ хэмээн ойлгуулж байгаа нь улс төрөөс хараат бус байх ёстой академик орчны ёс зүйд харшилж байгааг онцгой анхаарна уу.

1.10 Үүрэг гүйцэтгэгчийн дээрх бусармаг үйлдэл, шийдвэрүүд нь 75 жилийн түүхтэй МУИС-ийн эрдмийн хамт олныг илтгэд доромжилсон, үнэт зүйлийг гутаасан, академик эрх чөлөөг боомилсон, шударга бус зүйлийг дэмжсэн, нийгэмд урхагтай хэрэг хэмээн үзэж байгаа бөгөөд МУИС дээр болж байгаа бүх л хууль бус ажлыг намын томилгоотой хүмүүс хийж байна. Монгол Ардын Намын мөрийн хөтөлбөрт тусгасны дагуу МУИС-ийн захирлын томилгоо **улс төрөөс хараат бус** байх ёстой.

2. МУИС-ИЙН СУРГАЛТЫН ЧАНАР УРУУДАХ НӨХЦӨЛ БҮРДЛЭЭ

2.1 Я.Төмөрбаатар нь бүрэлдэхүүн сургуулиудын сургалтын албыг татан буулгаж, сургалтын нэгдсэн газрыг байгуулан удирдлагыг нь туршлагагүй хүмүүсээр бүрдүүлсэн нь их сургуулийн сургалтын хэвийн үйл ажиллагааг илтэд дордуулсан.

2.2 МУИС-ийн хамгийн гол анхаарч ажиллах ёстой сургалтын чанар энэ хугацаанд асар ихээр уруудлаа. Уруудалтын үндсэн шалтгаануудын нэг нь шаардлага хангаагүй оюутнуудыг элсүүлэх болсон явдал. Тодруулбал, Я.Төмөрбаатар нь **ЭЭШ-ын оноогүй**, эсвэл ЭЭШ-ын оноо доогуур хүүхдүүдийг онооны эрэмбээр бус **өргөдлөөр** элсүүлсэн зэрэг МУИС-ийн элсэлтийн дүрэм журмыг зөрчин элсүүлсэн **300 орчим** оюутан байгаа гэх мэдээллийг шалгаж өгнө үү.

3. МУИС-ИЙН САНХҮҮГИЙН САХИЛГА БАГ АЛДАГДАЖ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШИГГҮЙ ЗАРЦУУЛАЛТ ЭРС НЭМЭГДСЭН

3.1 Я.Төмөрбаатар МУИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчээр ирснээс хойшхи ил тод байх ёстой **худалдан авалт, тендергүй** холбоотой бүх гэрээ, гүйцэтгэлүүдийг маш нууц ангилалд оруулж, “Эдийн

засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль”, “Шилэн дансны тухай хууль”-ийг **ноцтой зөрчиж** байгаа тул шалгаж өгнө үү. Тухайлбал, номын сан, хичээлийн болон оюутны дотуур байрны засвар, үйлчилгээ, сургалтын тоног хэрэгсэл, компьютер худалдан авалт гэх зэрэг.

3.2 Төрийн өмчит МУИС-ийн номын санг **16 тэрбум** төгрөгөөр барьсан гэдэг ч тоног төхөөрөмжийн хамт **22 тэрбум** төгрөгөөр боссон гэх мэдээ байгаа тул Монгол Улсын хуулийн дагуу шалгаж, аудит оруулж өгөхийг хүсч байна. Ашиглалтад ороод нэг сар ч бололгүй зоорийн давхарт 80 тонн ус алдаж, олон ховор ном усанд автсаныг номын сангийн захирал С.Цэрэн, захирал Я.Төмөрбаатар нар багш, ажилтнуудад мэдэгдүүлж болохгүй хэмээн нууцалсан зэрэг нь тендерийн гүйцэтгэл, чанарын шаардлага хангаагүй барилгыг хүлээн авснаас үүдэлтэй, асар их хохирол учруулсан хэмээн үзэж байна. (Хавсралт 6)

3.3 “МУИС-75 жил” **ойг** тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төсөвлөсөн гэх боловч юунд, хэрхэн зарцуулсан нь ил тод бус байна. Гэтэл энэ нь төрийн өмчит сургуулийн хувьд нэг удаагийн арга хэмжээнд санхүүгийн үрэлгэн байдлыг дээд зэргээр өсгөн, шамшигдуулсан хэрэг гэж үзэх үндэстэй юм. Төрийн байгууллага, албан тушаалтнуудыг ойн арга хэмжээ тэмдэглэх, элдэв арга хэмжээнээс татгалзан хэмнэлтийн горимоор явахыг үүрэгдсэн Ерөнхий сайдын бодлогын эсрэг арга хэмжээ гэж үзэж байна. Тухайлбал, ойн хүрээнд МУИС-ийн сургалт үйл ажиллагаанд огтоос хамааралгүй **шар хэвлэл болох “Зиндаа” сэтгүүлд** ойролцоогоор **55 сая төгрөг** зарцуулж, МУИС-ийг бус өөрийн багт багтсан **хувь хүмүүсийг сурталчилсан** нь МУИС-д зайлшгүй шаардлагатай сургалтын болон багш, ажилтан, оюутнуудын эн тэргүүний хэрэгцээг зардалд зарцуулах хэрэгцээг огоорсон, ёс зүй, санхүүгийн сахилга батыг **ноцтой зөрчсөн** үйлдэл хэмээн үзэж байна. (Хавсралт 7) Ойн арга хэмжээнд зарцуулсан төсөв, түүний үр ашгийг шалгаж өгнө үү.

3.4 Я.Төмөрбаатар нь 2017 оны тавдугаар сарын 19 өдрийн тушаалаар МУИС-ийн Хангамж үйлчилгээний хэлтсийн даргаар ажиллаж байсан Ш.Гончигсүрэнд МУИС-ийн төвлөрсөн сангаас 5 сая төгрөгийг олгосон хэдий ч удаах тушаалаараа Хангамж үйлчилгээний хэлтсийг буулган

Хангамж үйлчилгээний газрыг шинээр байгуулан **Винтовын Алтансүхийг** даргаар нь томилон үр ашиггүй зардал гаргасан байна. (Хавсралт 8)

3.5 Я.Төмөрбаатар ба түүний удирдлагын багийнхан томилогдсноос хойш гадаад ба дотоодод олон тооны томилолтуудыг хийсээр байгаа нь МУИС-ийн хамт олны дургүйцлийг асар ихээр төрүүлж байна. Эдгээр томилолтуудын талаарх мэдээлэл нууцын зэрэглэлд байгаа тул томилолтын эдийн засгийн болон эдийн засгийн бус үр ашгийг шалгаж өгнө үү. (Хавсралт 9: 2018 оны 1 сарын 11-13 өдрүүдэд Эрдэнэт хотод хийсэн томилолтын төлөвлөгөө)

4. МАН-ЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨРТ ТУСГАСНЫ ДАГУУ МУИС-ИЙН ЗАХИРЛЫН ТОМИЛГОО УЛС ТӨРӨӨС ХАРААТ БУС БАЙХ ЁСТОЙ

МУИС-ийн нэр хүнд, ёс зүйн хэм хэмжээг унагаж буй МУИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгч Я.Төмөрбаатар болон Хууль бусаар докторын зэрэг олж авч, багш нарын холбооны нэрээр албан тушаалд томилогдсон П.Лхамсүрэн, дүрмийн бусаар эрдмийн цол авч, албан тушаалдаа хариуцлагагүй ажилласан Ч.Ундрам нар нь шинжлэх ухаан, их дээд боловсролын байгууллагад ажиллах ёс зүйгүй хэмээн үзэж байна.

МУИС-ийн сургалтын болон бусад үйл ажиллагааг муутгаж, ажлын хариуцлага, эмх цэгц доголдож, МУИС-ийн өрсөлдөх чадварыг олон улсад төдийгүй дотоодод эрс бууруулж буй удирдлагуудад хамт олны дургүйцэл, уур бухимдал дээд цэгтээ хүрч, шударга бус, алагчилсан, албан тушаалаараа давуу байдал үүсгэсэн, хууль бус үйлдэлд цэг тавих цаг болсон хэмээн үзэж байна.

Иймд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх та хууль, эрх зүйн талаасаа үндэслэлтэй МУИС-ийн багш нарын санал, шаардлагыг хүлээн авч, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан, дээрх ноцтой зөрчлүүдийг нэн яаралтай шалгаж, **МУИС-ийн захирлын сонгон шалгаруулалтыг намын томилгоо, улс төрийн нөлөөллөөс ангид, хуулийн хүрээнд зарлан, шударгаар** явуулахад онцгой анхаарал хандуулахыг хүсч байна.

Асуудлыг шуурхай шийдвэрлэхгүй бол МУИС-ийн багш ажилтнууд бид тэмцлийн дараагийн шатанд шилжих болохоо үүгээр илэрхийлж байна.

МУИС-ИЙН БАГШ НАРЫН ТҮР ХОРОО

ЗГМ: Сэдэв

Эмэгтэйчүүд эрэгтэй хүнийг бодвол маш хурдан архинд донтдог

Г.Оюунтөгс
@oyuntugsZGM

Арван жил сархадын амтанд донтож, золиосонд нь амьдрал, бүр үр хүүхдээ өгсөн гэж 30 настай А ярих. Нөхөр нь өөр хүнтэй суусан тул тэрбээр архинд орж, үр хүүхэд, гэр бүлийнхнээсээ нүүрээ



Б.Ганбаяр / ЗГМ©

Сархдад самуурсан “цэцэгс”

буруулж, гэрлэлтээ цуцлуулжээ. Улмаар архины мөнгө олохын тулд хулгай хийж эхэлсэн гэдгээ тэрбээр нуусангүй.

Тэгвэл Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн архинаас гаргах эмчилгээ буюу өөртөө туслах бүлэгт зөвхөн өнгөрсөн жил гэхэд 120 гаруй хүн уг эмчилгээнд хамрагдсан байна. Үүний тал орчим хувь нь эмэгтэйчүүд гээд бод доо. Улсын хэмжээнд 2016 онд 187366 хүн саатуулах байранд саатуулагджээ. Үүнээс 4925 нь 25-45 насны эмэгтэйчүүд. Мөн Наркологийн эмнэлэгт 1992 хүн архинаас гаргах эмчилгээнд хамрагдсан 339 нь эмэгтэйчүүд байжээ. Товчхондоо, архинд донтох эмэгтэйчүүдийн тоо жил ирэх тусам эрс нэмэгдэж буйг дээрх тоо баримт нотлон харуулж байна.

Архины эмчилгээ хийлгэсэн эмэгтэйчүүдийн дунд гурван сартай нялх хүүхэдтэй эх хүртэл байсан аж. Энгэрт нь ангир уураг эвлэж сүүний үнэр шингэсэн монгол бүсгүй сархадын гашуун амтанд дурлаж, амьдралаа алддаг цөвүүн цаг ирсэн үү. Сархад

эрчүүдийг залгисан байтал хорвоогийн сайхан эмэгтэйчүүд автаж эхэллээ гэж хэлэхэд хилсдэхгүй нь. Аавууд архинд донтсон байна. Аавын араас шаналсан ээж архиар элгээ дэвтээж сууна. Гэтэл бас бяцхан охид самуурч байна. Энэ бол Монголын амьдралын төрх.

Эмэгтэйчүүд 2-5 жилийн дотор архинд донтдог

Эмэгтэйчүүдийн архинд донтох өвчин нийгмийн байдлаас ихээхэн хамаардаг гэдгийг СЭМҮТ-ийн Донтох эмгэгийн клиникийн өдрийн эмчилгээний их эмч Б.Соёлмаа хэлэв. Тэрбээр эмэгтэйчүүд ядуурал, ажилгүйдлээс болж сэтгэлээр унаж, стрессээ тайлах гэж архи уудаг. Эхний үед найз нөхөдтэйгөө нийлж дарвиж, цалин буух, төрсөн өдрийг алгасахгүй тэмдэглэж баар, цэнгээний газарт ордог. Гэвч

энэ нь донтох эмгэг рүү аажмаар хөтөлж, эцэс сүүлдээ архины хараат байдалд оруулдаг.

Эмэгтэйчүүд эрэгтэй хүнийг бодвол биеийн онцлогоосоо шалтгаалж, маш хурдан архинд донтдог аж. Хүний биед этилийн спирт задалдаг фермент бий. Гэвч эмэгтэй хүнд маш сул үйлчилдэг байна. Иймээс сэтгэл зүйн тогтворгүй байдал, ферментийн үйлчилгээнээс шалтгаалаад эмэгтэйчүүд 2-5 жилийн дотор архины хамааралтай болдог аж. Ингээд архинд донтсоноор ууртай, уцаартай болж, архи уухын тулд худлаа ярьж, хулгай хийн, залилах гэмт хэрэг үйлдэж, зан төрхийн эмгэгтэй болж, сэтгэцийн өөрчлөлттэй болдог байна.

АРХИНЫ ЭМЧИЛГЭЭ МОНГОЛ УЛСАД ДЭЛХИЙН ЖИШГЭЭС ХЯМД

ДЭМБ-аас хийсэн судалгаагаар ОХУ-д архинд донтсон эмэгтэйн тоо жил тутам 9000 орчмоор нэмэгдэж, 500 орчим гэр бүл салдаг аж. Тус улсад архины эмчилгээ багтраа, нойр булчирхайн

үрэвсэл, чихрийн шижин зэрэг хүнд өвчнийхөөс үнэтэй тусдаг байна. Үүгээр ч зогсохгүй олон улсад нэг хүнд ногдох сархадын хэмжээ жилд таван литр орчим байдаг аж. Гэтэл Монгол Улсад нэг хүнд ногдох сархадын хэмжээ 11.7 литр бөгөөд архины эмчилгээ хамгийн хямд. Эрх мэдэлтнүүдийн гаргасан шийдвэрээр архины хордлогод орсон хүн эмнэлэгт очоод 35 мянган төгрөг төлөөд л хордлогоо тайлуулаад эмчилгээ хийлгэж болдог. Тэр ч бүү хэл, гудамжинд согтоод унасан хүнийг хамгийн ойрхон дүүргийн харьяа эмнэлэгт хүргэж, эмчилгээ хийдэг. Хэдийгээр төр иргэнээ бүхий л талаар хамгаалах ёстой ч зарим нэг харалган шийдвэр нийгмийн бараан амьдралыг хөхиүлэн дэмжиж буйг салбарын мэргэжилтнүүд хэлж байна. Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байрны зохицуулагч М.Содгэрэл “1990-ээд оноос хойших эмэгтэйчүүд архины хамааралтай болох нь ихэссэн. Үүний улмаас үр хүүхэд

нь үл хайхрах хүчирхийлэлд өртөж байна” гэдгийг хэлсэн юм.

ХЭВЛИЙДЭЭ ҮРЭЭ ТЭЭЧИХЭЭД ЦЭНГЭЭНИЙ ГАЗАР ХЭСЭЖ БАЙГАА НЬ ЭМГЭНЭЛТЭЙ

Арав гаруй жил БНСУ-д ажиллаж байгаад ирэхэд гэрийнх нь хаалга онгорхой, эхнэр нь орон дээрээ согтчихсон хэвтэж байсан тухай нэгэн залуу ярих. Архи ууж, хөлчүүрхсэн эхнэр нь том хүүтэйгээ өдөр шөнөгүй ноцолдож, хоёр гарыг нь хумсаараа юу ч үгүй сийчжээ. Харин бага хүү нь гэртээ байгаа ээжээсээ айхын эрхэнд гэртээ орж балга ус уучихаад өдөржин байрныхаа гадаа өнждөг байсан аж. Ингэж явсаар том хүү

нь гэрээсээ дайжиж, найз нөхдийндөө хоног төөрүүлж, хар бор ажил хийдэг болсон байна. Харин бага хүүгээ тэрбээр өөр дээрээ авч хамт амьдарч байгаа ч нэгэнт гадуур яваад сурчихсан хүүхдээ аргамжиж чадахгүй яваагаа хэлсэн юм. Ганц энэ жишээний цаана ийм амьдралтай олон гэр бүл байгаа нь эмгэнэлтэй. Хэзээнээс эрчүүдээсээ илүү эмэгтэйчүүд нь агсам согтуу тавьж, балчир үрсээ айлгаж, ичээдэг болчихов. Хэвлийдээ хүртэл үрээ тэчиххээд цэнгээний газар хэсэж, айж, ичих нь битгий хэл олны дунд толгой цохиж байгаа нь харамсалтай.

Иймээс согтууруулах ундааны нэг удаагийн хэрэглээний үндэсний стандарт хэмжээг тогтоож, хуулийн хатуу бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна. Нэн даруй аргамжихгүй бол савнаасаа бусдыг дийлдэг сархад охид бүсгүйчүүдийг сэвтүүлэх нь. Хэн хүнгүй анхаарахгүй бол үр хүүхдүүд нь хүртэл эхийнхээ хэвлийгээс мэндлэхдээ архинд донтох эмгэгтэй төрөх аюул нүүрлээд байна. [ЗГМ]


ЗГМ: ИНФОГРАФИК



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 01 дүгээр сарын 22 ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **ТА №5-ын туслах тоноглолын их засварын ажил хийж гүйцэтгэх**
Тендер шалгаруулалтын дугаар: **ТЗ-2018/003**
“ДЦС-4” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос “ТА №5-ын туслах тоноглолын их засварын ажил хийж гүйцэтгэх” тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.
Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.
Тендер оролцогч нь тендер илгээхийн өмнө 100.000 (Зуун мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.
Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.
Тендер оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
1. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн жил тус бүрийн борлуулалтын орлого нь тендер санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. 2016, 2017 он тус бүрээр
2. Түргэн хорвох чадвартай хоронго болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендер санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.
3. Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: сүүлийн 2 жил. 2016, 2017 он
4. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Тендер санал болгосон үнийн дүнгээс багагүй байх (2016, 2017 он)
5. Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: Шаардлагатай /80кг/см2-аас дээш даралттай зуухны угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах үйлчилгээ, /80кг/см2-аас дээш даралтанд ажилладаг тоноглолын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ,
Тендерийн хамт 4,738,000 дүнтэй тендерийн баталгаа ирүүлднэ.
Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгаа хүлээн зөвшөөрнө.
Хүчинтэй байх хугацаа: 2018 оны 05 дугаар сарын 07 -ний өдөр дуустал
хүн амын наслалт өндөрсөж, ажиллах хүчний дутагдал үүсэж болзошгүй байгааг эдийн засагчид анхааруулав. Ийм байдал нийгмийн халамжийн ачааллыг нэмэгдүүлэх үр дагавартай. Өндөр хөгжилтэй орнуудад хүн амын өсөлт хэдэн арван жил буурч байгаа бөгөөд Хятад улс тэдгээрээс нэг хүнд ногдох үндэсний орлогоор хоцорсон хэвээр байна. Ноён Уайт "Өндөр хөгжилтэй орнуудад урт хугацаанд тулгарч буй бэрхшээл Хятад улсад үүсээд байна" гэв. Энэ зууны дундуур Хятадын

гурван иргэний нэг нь 60-аас дээш настай байх төлөвтэй байна. Бээжин тус улсын хүн амын тоо 2030 онд дээд хэмжээ буюу 1.4 тэрбумд хүрээд аажмаар буурна гэж тооцдог. Хятадын төрөлтийг 1990 оноос хойш 90 саяар хэтрүүлэн тооцсон гэсэн дүгнэлт байдаг агаад судалгаанаас үзэхэд тус улс төрөлтийг нэмэгдүүлэх арга хэмжээ авахад хүрчээ. Гэвч иргэд хүүхдийн боловсролд илүү анхаардаг болсон учир төрөлт буурч байна гэж шинжээчид таамаглажээ. Хүн ам зүйчдийн ярьснаар ийм хандлага 1979 онд

нэг хүүхдийн бодлого хэрэгжиж эхлэхээс өмнө ажиглагдаж эхэлсэн ба одоо бодлогыг үл харгалзан үргэлжилсээр байгаа аж. Оксфордын их сургуулийн хүн ам судлалын мэргэжилтэн Стюарт Гител-Бастен "Хятадад айл өрх болж, хүүхэд төрүүлнэ гэдэг хүнд асуудал. Гэрлэлтийн нас аажмаар нэмэгдэж байгаа нь мөн төрөлтөд нөлөөлж байна" хэмээн ярилаа. Төрөлт буурч буйг сөрөхийн тулд зарим иргэн татвараас чөлөөлөх, татаас олгох гэх мэт арга хэмжээг хэрэгжүүлэхийг уриалжээ. Хя-

тадын хөдөөд нэг хүүхдийн бодлогыг хатуу хянадаггүй байсан учир хоёр хүүхдийн шинэ бодлого голдуу хотын иргэдэд чиглэсэн юм. Гэвч хотын иргэд цөөн хүүхэдтэй байхыг илүүд үздэг болсон нь хотын эмэгтэйчүүд илүү боловсролтойгоос гадна хүүхэд өсгөх зардал өндөр байдгаас шалтгаалжээ. Ноён Гител-Бастен "Бодлогын өөрчлөлт цөөн хүүхэдтэй байхыг эрхэмлэдэг хотын гэр бүлд илүү нөлөөлсөн" гэж үзсэн байна.



© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Шон Доннан

БНХАУ-ыг Дэлхийн худалдааны байгууллагад (ДНБ) элсэхийг зөвшөөрсөн нь алдаа байсныг Трампын засаг захиргаа тайлбарлаад Бээжинг зах зээлийн эдийн засгаас нүүр бурууллаа хэмээн зэмлэв.

АНУ-ын худалдааны төлөөлөгч Роберт Лайтхайзерын тайланд дурдсан тайлбар нь дэлхийн гол хоёр эдийн засгийн хооронд худалдааны харьцаа хурцдаж буйн илрэл. Мөн уг тайлбар нь 2001 онд Бээжин ДХБ-д элссэнээс хойш АНУ гаруй жил баримталж ирсэн байр сууринаас Вашингтон ухарч буйн баталгаа боллоо.

БНХАУ-ыг ДХБ-д элсүүлсэн нь Бээжинг дэлхийн тавцанд байр суурийг нь эзлүүлж, худалдааны болзошгүй дайнаас зайлсхийсэн хэрэг хэмээн АНУ-ын Ардчилсан, Бүгд найрамдах намын гишүүд аль аль нь тайлбарлаж ирсэн түүхтэй.

Бусадтай худалдаа хийхийг эрмэлзэгч зах зээлийн эдийн засагтай улсуудын клуб байж



BVM©

БНХАУ-ыг ДХБ-д элсүүлсэн нь Бээжинг дэлхийн тавцанд байр суурийг нь эзлүүлж, худалдааны болзошгүй дайнаас зайлсхийсэн хэрэг хэмээн АНУ-ын Ардчилсан, Бүгд найрамдах намын гишүүд аль аль нь тайлбарлаж ирсэн түүхтэй.

“тогтолцоо”-ны бэрхшээлийг залруулах нь энэ онд Трампын захиргаанаас анхаарах гол сэдвийн нэг байхыг Цагаан ордны дээд албаны эрхэм өгүүллээ. Гажигтай ажилладаг ДХБ-д албадан шинэчлэл өрнүүлэх нь ч Трампын засаг захиргааны бас нэг зорилго хэмээн дээрх эрхэм мэдэгдэв.

Цагаан ордныг “хэт дэндүүлсэн мэдэгдэл” хийсэнд нь Гадаад харилцааны зөвлөл (Council on Foreign Relations) хэмээх судалдааны байгууллагын ахлах судлаач Эдвард Алден шүүмжиллээ. Хятадыг элсүүлсэн нь алдаа гэж үзсэн тайлбар нь АНУ-ын гол хоёр засаг сүүлийн 20 гаруй жил баримталж ирсэн байр суурьтай эрс зөрчилдөж байгааг судлаач анхааруулсан юм.

“Хятад улсыг ДХБ-д элсүүлсэн нь түүхэн чухал үйл явдал гэж Клинтон засаг захиргаа үзсэн. Энэ нь Хятад улсын эдийн засгийн хүчирхэгжлийг хүлээн зөвшөөрсөн төдийгүй өнөөгийн тогтолцоонд байр суурийг нь

Хятадыг ДХБ-д элсүүлсэн нь алдаа гэж АНУ үзлээ

ирсэн ДХБ-ыг БНХАУ, ОХУ хоёр ганхуулан сулруулж байна хэмээн ноён Лайтхайзер шүүмжилжээ.

Зах зээлээ гадаад худалдаанд нээж, шударгаар өрсөлдөх сонирхолгүй том эдийн засагтай улсууд дэлхийн худалдааны тогтолцоонд заналхийлж байгааг тайлбарласан тэрбээр Хятадын үйл ажиллагаа “ДХБ-ын суурь зарчимд харш” хэмээн тодорхойлов.

“Хятадыг ДХБ-д элсүүлэхийг

АНУ дэмжсэн нь алдаа. Учир нь нээлттэй, зах зээлд чиглэсэн худалдааны тогтолцоо үүсгэхээр АНУ-ын өмнөх засаг захиргаанд өгсөн амлалтаа Бээжин хөсөрдүүлсээр ирлээ” хэмээн Цагаан орноос Конгресст жил тутам тавьдаг тайланд тайлбарлажээ.

Бээжин байр сууриа өөрчлөхөөс аргагүй нөхцөл үүсгэхийн тулд ДХБ-аас гадуур, олон талын

оролцоот шинэ хэрэглүүр үүсгэхийг ноён Лайтхайзер уриалав.

Цагаан ордны байр суурь нь Бээжин, Вашингтоны хооронд “таарсан хариуг нь өгөх” сүйрүүлэгч шинжтэй худалдааны дайн дэгдэх аюултайг зарим шинжээч анхааруулж байна.

АНУ цаашид ч Хятадын эсрэг тэмцэлдээ ДХБ-ыг ашиглахаа Цагаан ордны дээд албаны эрхэм

баасан гарагт тайлбарлав. Гэхдээ ийм тэмцэл ихэнх тохиолдолд үр дүнгүй өнгөрч болзошгүй тул Вашингтон шаардлагатай нөхцөлд ганцаар тэмцэнэ гэдгийг уг эрхэм өгүүлсэн юм.

Трампын засаг захиргаа БНХАУ-ын эсрэг хэд хэдэн арга хэмжээ авахаар эргэцүүлж байна. Эдгээр арга хэмжээ нь Хятадад бизнес эрхлэх гадаадын компаниудаас чухал техно-

логио шилжүүлэхийг шаарддаг Бээжингийн практикийг мөрдөн шалгах аргаар жилийн өмнө эхэлсэн шалгалтад төвлөрнө.

БНХАУ-тай харьцах харилцаа, худалдааны төлөвлөгөөгөө ноён Трамп энэ сарын эцсээр Конгресст илтгэл тавихдаа тайлбарлана.

АНУ-ын эдийн засгийг хохироож буй Бээжингийн аж үйлдвэрийн бодлого, оюуны өмчийн дэглэмтэй холбоотой

эзлүүлж, ирээдүйн болзошгүй сөргөлдөөнөөс зайлсхийхийн тулд гаргасан шийдвэр” хэмээн ноён Алден өгүүллээ.

Цагаан ордны тайлан нь Трампын засаг захиргаа Бээжинтэй худалдааны дайн өрнүүлэх санаархалтайн илрэл хэмээн өмнөх Ерөнхийлөгч Барак Обамагийн худалдааны зөвлөх байсан Чад Баун үзэж байна.



Coca-Cola хуванцар хаягдлаа багасгахаар чармайж байна

Анна Николау

Далай тэнгис хуванцар дүүрч буй бэрхшээлийг шийдвэрлэх үүднээс дэлхий нийтийн хүчин чармайлтад хувь нэмрээ оруулахаар Coca-Cola компани хаягдлаа багасгахаа амлав.

Жилдээ 120 тэрбум хуванцар сав ашигладаг ундаа үйлдвэрлэгч 2030 он гэхэд нийт сав баглаатай нь тэнцэхүйц хэмжээний дахивар цуглуулж ашиглахаар төлөвлөжээ. Тус компани 2030 оноос нийт сав баглааныхаа 50 орчим хувийг дахин ашиглах юм.

“Хараа хяналтгүй орхивол та бидний далай тэнгис, гол мөрөн хуванцар хаягдлаар аажимхан дүүрэх нь” хэмээн Сосо-Cola-гийн захирал Жэймс Квинси блогтоо бичжээ.

Одоогоор тус компани хуванцар лонхныхоо 10 хүрэхгүй хувийг хөнгөн цагаан лаазныхаа бараг 50 хувийг дахивар материалаар үйлдвэрлэдэг. Coca-Cola зардал хэмнэхийн тулд баглаа, савлагааныхаа технологийг сайжруулахад үлэмж хэмжээний хөрөнгө оруулахаар төлөвлөөд байна.

Coca-Cola нь Засгийн газар, аж үйлдвэрийн салбарын дэмжлэгт тулгуурлан, тодорхой зах зээлд дахивар нийлүүлэх сүлжээ байгуулах замаар хаягдал цуглуулах технологио өөрчлөх туршилт ид явуулж байна. Европ тив жил бүр 25 сая тонн хуванцар хаягдал ялгаруулдаг. Үүнийг 60 гаруй хувь нь сав, баглаа боодлын хаягдал. Зөвхөн Их

Британид жил бүр хаяж буй ганц удаагийн хэрэглээний хуванцар хаягдал Рояль Альберт Холлыг (тайлбар: Лондон дахь алдартай концертын танхим) 1000 дахин дүүргэхүйц гэдгийг Тереза Мэй энэ долоо хоногт дурдсан юм.

Хог хаягдлыг багасгахад Засгийн газруудын хүчин чармайлт ч ихэссээр. Бүх сав, баглаа боодлыг 2030 он гэхэд дахин ашиглахыг Европын холбоо энэ долоо хоногт уриалав. “Манай үеийн хамгийн аварга гамшигийн нэг”-ийг арилгах үүднээс шаардлагагүй хуванцар хаягдлыг 2042 оны эцэс гэхэд бүрмөсөн үгүй болгохоор хатагтай Тереза Мэй энэ сарын эхээр амласан юм.

Хийжүүлсэн ундааны үйлдвэр-



BVM©

Жил бүр 120 тэрбум хуванцар лонх ашигладаг Coca-Cola дахивар ашиглахаа амлаж байна.

лээр дэлхийд тэргүүлэгчийн амлалт нь хуванцар хог хаягдлыг үгүй хийх хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн хүчин чармайлтын нэг бүрдэл. Бүтээгдэхүүний бүх сав, баглаа, боодлыг 2025 он гэхэд дахивар ашиглан үйлдвэрлэхээ

McDonald's энэ долоо хоногт зарлав. Их Британийн хүнсний Iceland компани бохирдлын “гамшиг”-ийг арилгах үүднээс 2023 оноос эхлэн бүтээгдэхүүнийхээ сав баглаа боодолд хуванцар ашиглахыг зогсоохоо мэдэгдлээ. Danone-ийг эзэмшигч

Evian компани 2025 он гэхэд хуванцар лонхоо зөвхөн дахивар ашиглаж үйлдвэрлэхээ зарлав.

Unilever, Mars, PepsiCo, Marks and Spencer, Procter & Gamble компани ч дээрхтэй төстэй үүрэг амлалт аваад байна.



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Тусгай зориулалтын регулятор ба үл буцах клапан нийлүүлэх**

Тендер шалгаруулалтын дугаар: **МС-20/2018**

“ДЦС-4” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос “Тусгай зориулалтын регулятор ба үл буцах клапан” нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендер оролцогч нь тендер илгээхийн өмнө 50.000 /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн, жил бүрийн борлуулалтын орлого нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.,2016, 2017 он тус бүрээр

2. Түргэн хорвох чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.

3. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: 2016,2017 тус бүрээр/нохтох баримтын хамт/ сүүлийн 2 жилийн дун Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй ижил төстэй гэрээт ажил гүйцэтгэсэн байна.

Тендерийн хамт тендерт санал болгосон үнийн дүнгийн 2%-тай тэнцэх дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгаа хүлээн зөвшөөрнө.

Тендерийг 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 10.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

Монгол улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж, “ДЦС-4” ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 312, 313 тоот өрөө Худалдан авах ажиллагааны хэлтэс Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс 7018-13097000-1357

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Төрөл бүрийн ган уур ус таслагч нийлүүлэх**

Тендер шалгаруулалтын дугаар: **МС-21/2018**

“ДЦС-4” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос “Төрөл бүрийн ган уур ус таслагч” нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендер оролцогч нь тендер илгээхийн өмнө 50.000 /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн жил бүрийн борлуулалтын орлого нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.,2016, 2017 он тус бүрээр

2. Түргэн хорвох чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.

3. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: 2016,2017 тус бүрээр/нохтох баримтын хамт/ сүүлийн 2 жилийн дун Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй ижил төстэй гэрээт ажил гүйцэтгэсэн байна.

Тендерийн хамт тендерт санал болгосон үнийн дүнгийн 2%-тай тэнцэх дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгаа хүлээн зөвшөөрнө.

Тендерийг 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 10.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

Монгол улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж, “ДЦС-4” ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 312, 313 тоот өрөө Худалдан авах ажиллагааны хэлтэс Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс 7018-13097000-1357

Эдийн засаг

БАЙР СУУРЬ

Ипотекийн урьдчилгааг бууруулах санал боловсруулж байна

Энэ онд барилгын салбар бүхэлдээ завгүй, ажлын байр их бий болно

З.Гэрэл
ЗГМ

Барилга, хот байгуулалтын сайд Х.Бадельхантай энэ онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын талаар ярилцлаа.

-Ипотекийн зээлийн ажил ямар шатанд байна вэ?

-Ипотекийн зээлийг үргэлжлүүлэхэд улсын төсвөөс 120 тэрбум, Монголбанкнаас зээлийн эргэн төлөлтийн 200 гаруй тэрбум төгрөгийг энэ онд зарцуулахаар төлөвлөсөн. Өөрөөр хэлбэл, сард 16-18 тэрбум төгрөг төвлөрнө гэсэн үг. Хэдийгээр хөрөнгийн эх үүсвэр бэлэн байгаа ч хэмжээг нь нэмэгдүүлэх шаардлагатай байна. Тиймээс ипотекийн зээлийн схемийг сайжруулах, хүртээмжийг нь нэмэгдүүлэхээр Сангийн сайдын тушаалаар Ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг нийслэлд төвлөрөл үүсэхээс сэргийлэх зорилгоор орон нутаг болон гэр хорооллын дахин төлөвлөлтөд орсон газрыг орон сууцжуулахад анхаарч, зээлийн хүүг бууруулах боломжийг судлах юм. Мөн зээлийн урьдчилгааг бууруулах гарц шийдлийг эрэлхийлж байна.


-Барилгын компаниудыг хэрхэн дэмжих вэ?

-Зах зээлд 30 гаруй мянган орон сууц бэлэн байна. Эдгээр орон сууцыг барилгын компани зээл аваад босгочихсон. Нөгөө талаар иргэд зээл авч орон сууцанд орохыг хүсэж байна. Тэгэхээр энэ нь эргээд ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх тухай л шийдэл юм. УИХ-ын тогтоолоор төр,



Б.Ганбаяр / ЗГМ

ЗГМ: ИНФОГРАФИК



арилжааны банкууд, барилгын компаниудтай хамтраад бэлэн орон сууцыг борлуулах боломжийг судлахаар ажиллаж байна. Хамгийн гол нь хоёр жилийн хугацаанд ОУВС-гийн гэрээний дагуу Засгийн газрын бодлого явагдах ёстой. Гэрээ дууссаны дараа өөрсдөө бие дааж шийдэж болно. Тиймээс 1-2 жилийн хугацаанд төр, хувийн хэвшил, арилжааны банкууд тохирч, шаардлагатай тохиолдолд харилцан буулт хийх замаар 30 мянган орон сууцыг борлуулах эсэхийг Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлэнэ.

-2018 онд цэцэрлэг, сургуулийн хэдэн шинэ барилга ашиглалтад орох вэ?

-Энэ оныг бүтээн байгуулалтын жил болгон зарласан. Энэ хүрээнд гурван ээлжээр хичээллэж байгаа сургуулиудыг хоёр ээлжтэй болгохоор ажиллаж байна. Цэцэрлэгийн 90 гаруй, сургуулийн 60 гаруй барилга босгох зардал 2018 оны улсын төсөвт тусгагдсан. Үүнээс гадна орон нутгийн саналаар оруулсан олон барилга бий.

-Гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих ямар бүтээн байгуулалт байгаа вэ?

-Барилгын салбарын бүтээн

байгуулалт нэлээд өргөн хүрээтэй. Хятадын зээл тусламжаар 300 сая ам.долларын өртөгтэй цэвэрлэх байгууламжийн барилгын ажлыг эхлүүлнэ.

Сард 16-18 тэрбум төгрөг төвлөрнө

Мөн тус улсаас буцалтгүй тусламжаар олгож байгаа 350 сая юанийн хөрөнгөөр Ногоон нуур орчимд 1800 айлын орон сууц барьж байгуулна. Тэрчлэн нийслэл хотын инженерийн шугам сүлжээг шинэчлэх ажлыг хоёр тэрбум юанийн буцалтгүй тусламжаар хийнэ. Энэ мэт томоохон бүтээн байгуулалтыг улсын төсөв болон гадаадын зээл тусламжаар өрнүүлэх тул барилгын салбар бүхэлдээ завгүй, ажлын байр ч ихээр бий болно. Орон нутгийн төвүүдийг мөн цэвэрлэх байгууламжтай болгохоор нэлээд хэдэн аймагт АХБ, Францын Засгийн газрын тусламжтай цэвэрлэх байгууламж барина. Тухайлбал, Орхон аймагт цэвэрлэх байгууламж ашиглалтад орсон, Дархан-Уулынх эхэлж байна, нисэхийнхийг энэ хавар ашиглалтад оруулна.

-Гэр хорооллыг дэд бүтэцжүүлэх төлөвлөгөө хэрхэн өрнөх вэ?

-Энэ чиглэлд хийгдэх гол ажил нь Хятадаас ирэх хоёр тэрбум юанийн буцалтгүй тусламжаар бүтээн байгуулах гэж буй гэр хорооллыг төвийн дэд бүтэцэд холбох ажил юм. Гэр хорооллын 200-250 айлын дунд инженерийн нэг шугам сүлжээ барьж, цэвэр ба бохир ус, халаалтыг нь нэгдсэн журмаар шийдэх юм. Төсөл нь бэлэн байгаа шүү дээ. Нэг ёсондоо бичил дэд бүтцүүд бий болгоно. Эхний ээлжинд нийслэл болон БХБЯ-ны санхүүжилтээр тус бүр нэг дэд бүтэц байгуулж, үлдсэнийг нь буцалтгүй тусламжаар байгуулна. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» БОНД

102.7

Ам.доллар. Олон улсын зах зээлд гаргасан "Гэрэгэ" бондын ханш баасан гарагт түүхэн дээд түвшинд буюу 102.7 ам.долларт хүрэв. "Гэрэгэ"-ийн ханш өнгөрсөн оны арваннэгдүгээр сарын дунд үеэс өсөж эхэлсэн байна.

» ХУВЬЦАА

1.54

Хувь. Хонконгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Mongolian Mining Corporation-ийн хувьцааны ханш сүүлийн нэг өдрийн дотор 1.54 хувиар буурлаа. 2018 он гарснаас хойш компанийн хувьцаа нийт 9.3 хувиар чангарч, 0.24 хонконг доллар болоод буй юм.

» АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

14.2

Хувь. 2017 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улс 471094 жуулчин хүлээн авчээ. Энэ нь 2016 онтой харьцуулахад 66938-аар буюу 14.21 хувиар өссөн дүн юм. Мөн голлох зах зээлийн 15 орны жуулчдын тоо 4.9-23.2 хувийн өсөлттэй байгаа бол Их Британи, Турк, Украйнаас ирж буй жуулчдын тоо буурсан дүн гарчээ.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ доллар	2,423.37
Евро	2,973.96
Япон иен	21.90
ОХУ рубль	42.81
БНХАУ юань	378.55
БНСУ вон	2.27

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Төрөл бүрийн ган хар лист сонгон шалгаруулах тендер.
Тендер шалгаруулалтын дугаар: MC-2018/024

"ДЦС-4" ТӨХК нь эрх бүхий тендэрт оролцогчдоос "Төрөл бүрийн ган хар лист" нийлүүлэгчийн тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендэрт оролцогч нь тендер илгээхийн өмнө 50.000 /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендэрт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн жил бүрийн борлуулалтын орлого нь 300 сая төгрөгнөөс багагүй байна. /2016,2017 он/

2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 300 сая төгрөгнөөс багагүй байна.

3. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын туршлага: Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 онуудын жилийн дүн нь 300 сая төгрөгнөөс багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байна.

Тендерийн хамт 6,000,000 /Зургаан сая / төгрөгийн үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө.

Тендерийг 2018 оны 02 дугаар сарын 22 -ны өдрийн 10.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендэрт оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 02 дугаар сарын 21 ний өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй. Монгол улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрх тооцохгүй. Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж, "ДЦС-4" ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 310 тоот өрөө Худалдан авах ажиллагааны хэлтэс Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс 7018-1309 7000-1357

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Тээрмийн бул тавагны элэгдэлд гэсвэртэй шаваасны утас сонгон шалгаруулах тендер.
Тендер шалгаруулалтын дугаар: MC-2018/028

"ДЦС-4" ТӨХК нь эрх бүхий тендэрт оролцогчдоос "Тээрмийн бул тавагны элэгдэлд гэсвэртэй шаваасны утас" нийлүүлэгчийн тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендэрт оролцогч нь тендер илгээхийн өмнө 50.000 /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендэрт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн жил бүрийн борлуулалтын орлого нь тендэрт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. /2016,2017 он/

2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендэрт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.

3. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын туршлага: Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 онуудын жилийн дүн нь тендэрт санал болгож буй үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн байна.

Тендерийн хамт 3,000,000 /Турван сая / төгрөгийн үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө.

Тендерийг 2018 оны 02 дугаар сарын 22 -ны өдрийн 10.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендэрт оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 02 дугаар сарын 21 ний өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй. Монгол улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрх тооцохгүй. Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж, "ДЦС-4" ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар 310 тоот өрөө Худалдан авах ажиллагааны хэлтэс Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс 7018-1309 7000-1357

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Өндөр температурын цавуу сонгон шалгаруулах тендер.
Тендер шалгаруулалтын дугаар: MC-2018/030

"ДЦС-4" ТӨХК нь эрх бүхий тендэрт оролцогчдоос "Өндөр температурын цавуу" нийлүүлэгчийн тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендэрт оролцогч нь тендер илгээхийн өмнө 50.000 /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендэрт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн жил бүрийн борлуулалтын орлого нь тендэрт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. /2016,2017 он/

2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендэрт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.

3. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын туршлага: Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 онуудын жилийн дүн нь тендэрт санал болгож буй үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн байна.

Тендерийн хамт 1,600,000 /нэг сая зургаан зуун мянган / төгрөгийн үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө.

Тендерийг 2018 оны 02 дугаар сарын 22 -ны өдрийн 10.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендэрт оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 02 дугаар сарын 21 ний өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй. Монгол улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрх тооцохгүй. Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж, "ДЦС-4" ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 310 тоот өрөө Худалдан авах ажиллагааны хэлтэс Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс 7018-1309 7000-1357

Эдийн засаг

Бизнесийн боломжоос хумслах төр

Урамшууллын талбар болсон төрийн өмчийг хумих сонирхол алга

Г.Байгал
@baigalZGM



Хэдхэн хоногийн өмнө татан буулгахаар болсон газрууд нь үйл ажиллагаа явуулаагүй, их хэмжээний өртэй, хөрөнгийн эх үүсвэргүй байсныг Засгийн газраас мэдээлэв.

Б.Ганбаяр / ЗГМӨ

Төр тоох ч үгүй, хувийн хэвшилтэйгээ өрсөлдсөөр. Хэдхэн хоногийн өмнө Батлан хамгаалах яамны удирдлагууд цэвэр усны шинэ үйлдвэрийн үүдийг нээж, тууз хайчилсныг та дуулав уу. Эх орны энхийг манадаг уг салбар энэ жилээс эхлээд ус, ундааны зах зээлд хүч сорихоор шийдсэн нь энэ. Цагт 0.5-1.5 литрээр савласан 2300 ширхэг ус үйлдвэрлэх хүчин чадалтай энэ үйлдвэр зэвсэгт хүчний бие бүрэгдэхүүний цэвэр усны хэрэгцээг хангаад зогсохгүй зах зээлд нийлүүлнэ хэмээн албаныхан мэдэгдэж байна. Үүнийг ч салбарын сайд нь сайшаан, зөвхөн зэвсэгт хүчин төдийгүй олон нийтийн хэрэгцээнд нийлүүлж болохоор эрдэсжүүлсэн цэвэр ус үйлдвэрлэж буй нь том ажил хэмээн үнэлжээ.

Дотоодын цэвэр усны зах зээлийн дийлэнхийг үндэсний бизнес эрхлэгчид үйлдвэрлэдэг. Тэд өнөөгийн хүчин чадалдаа хүрч, дотоодын хэрэгцээг хангахын тулд сүүлийн 30 орчим жил чармайн зүтгэсээр өдий хүрсэн. Гэтэл энэ зах зээлд нь төр хүч түрэн орж, хувийн хэвшилтэйгээ өрсөлдөж гэж байна.

Үндэсний үйлдвэрлэгчийн хүчин чадал хэдийнэ эрийн цээнд хүрч, олон улсын түвшинд

хүрчхээд байхад Батлан хамгаалах яам тусдаа үйлдвэртэй болох ямар шаардлага байна вэ. Ингээд эрх мэдлээр далайлгасан төр хувийн хэвшилтэй нэг талбарт өрсөлдөх нь.

● **Сүүлийн жилүүдэд эрчимтэй өрнөж байсан өмч хувьчлал өнгөрсөн оноос таг болсон.**

● **Банк, санхүүгийн салбартаа гадаадын гар хүргэдэггүй байсан БНХАУ хууль журмаа зөвлөлдөж эхэлсэн.**

● **Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын мэдээлснээр төрийн нэр дээрх өмч хөрөнгө 30 их наяд төгрөгийг давж байгаа аж.**

Тамга барьсан төр, бор зурхээр яваа хувийн хэвшил хоёрын хооронд ямар тулаан өрнөх нь тодорхой.

Төр ингэж хувийн хэвшлийн урдуур орж бизнес эрхэлдэг болоод удаж байна. Хаана л ашиг олчих зах зээл байна, тэнд төрийн гарт хүрчихсэн, хүч тэнцвэргүй тулаан эхлүүлж явдаг. Төрийн нэр барьсан түшмэд “бизнесийг боомилж, хувийн хэвшлийн өмч, эрх чөлөө, үнэт зүйл рүү хүч түрэн халдахаас сийхгүй.

Ийнхүү тамга, тэмдгээр далайлгасан эрх мэдэлтнүүд сүүлийн хэдэн жил монгол төрийг хэд дахин данхайлгасан. Татвар төлөгчдийн мөнгөийг гарын салаагаараа урсгаж, үр ашиггүй, өрийн хүүдий болсон олон өмч хөрөнгийг төрд авсан.

Төрийн өмчийн бодлого, зо-

хицуулалтын газрын мэдээлснээр төрийн нэр дээрх нийт хөрөнгө 30 их наяд төгрөгийг давсан аж. Энэ нь зургаан жилийн өмнөхтэй харьцуулахад 1.8 дахин нэмэгдсэн үзүүлэлт. Сүүлийн хэдхэн жилийн дотор төр ингэглээ данхайн томорчээ. Гэтэл энэ хугацаанд эрх мэдэлтнүүд улс орны төсөв, санхүүгийн байдал хүнд байна хэмээн уйлагнаж, иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийг өсгөлгүй өдий хүрсэн.

Нэр бүхий аж ахуйн нэгжүүдийг татан буулгаж буйгаа Засгийн газар энэ сарын эхээр мэдэгдэв. Энэ дунд нэрийг нь бараг сонсож ч байгаагүй компани цөөнгүй байна. “Аж үйлдвэрийн цогцолбор”, “Монгол тариалан корпораци”, “Монгол мах корпораци”, “Монгол тамга”, “Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” зэрэг төрийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгахаар болжээ. Өнөөг хүртэл манай төр тариалан эрхэлж,

махны үйлдвэрлэл явуулж бүр тоног төхөөрөмжийн түрээс хүртэл хийхээр зорьж байсныг үүнээс харчихаж болно. Хэдхэн хоногийн өмнө татан буулгахаар болсон энэ газрууд нь үйл ажиллагаа явуулаагүй, их хэмжээний өртэй, хөрөнгийн эх үүсвэргүй байсныг Засгийн газраас мэдээлэв.

Гэвч үүнтэй адил татан буулгах, нэгтгэн нийлүүлэх, хувьчлах шаардлагатай төрийн өмчит газрууд үүгээр дуусахгүй. Төрөөр овоглосон аж ахуйн нэгжүүд жил жилийн төсөвт томоохон дарамт болдог. Стратегийн ач холбогдол бүхий компаниудыг эс тооцвол үйлчилгээний салбарын олон амралтын газар, цогцолбор төрөөр овоглож, татаас авсаар. Дээрээс нь хувийн хэвшлийн санхүү, даатгалын үйлчилгээ олон улсын жишигт хүртлээ хөгжихөөд байхад энэ салбарын компаниуд ч төрийн өмчлөлд байсан хэвээр.

Дэлхий даяар эдийн засгаа нээлттэй, бизнест ээлтэй болгож, энгийн салбараас эхлээд стратегийн ач холбогдол бүхий салбаруудаа хүртэл гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад санал болгож байна. Банк, санхүүгийн салбартаа гадаадын гар хүргэдэггүй байсан БНХАУ өнгөрсөн жилээс эхлээд энэ чиглэлийн хууль журмаа зөвлөлдөж эхэлсэн. Дээрээс нь төрийн өмчийг цэгцлэх зорилгоо сүүлийн хэдэн жил тууштай хэрэгжүүлж байна. Цомхон атлаа ухаалаг төрийг цогцлоох бодлогын хүрээнд Хятадын төрийн өмчит компаниудын нэгдэн нийлэх хэлцлийн тоо 2013 оноос хойш 98-д хүрсэн байна. Улмаар олон салбарын томоохон компаниудыг хувьчилж, төр бизнесийн салбараас аль болох гар татаж, хувийн хэвшилдээ боломж олгосоор.

Гэтэл төрийн өмчийг цэгцлэх чиглэлд монгол төр хойрго хандсаар. Сүүлийн жилүүдэд эрчимтэй өрнөж байсан өмч хувьчлал өнгөрсөн оноос таг болсон. Дээрээс нь цэгцлэх шаардлагатай олон аж ахуйн нэгж байсаар байтал нэр төдий хэдхэн компанийн үйл ажиллагааг татан буулгаад л өнгөрч байна. Угтаа өр, алдагдлаас өөр өөртэй юм дагуулдаггүй улсын өмчит аж ахуйн нэгжүүдээс төр аль болох салах хүсэлтэй баймаар. Харин манайд “эвий минь” хэмээн өрөвдөн, төсвийн мөнгөөр тэжээсээр өдий хүрлээ. Өдгөө хэрэгжүүлж буй бодлогоос нь улс төрдөд ч төрийн өмчийг цэгцлэх сонирхол алга гэсэн дүгнэлтэд хүрч болохоор байна. Төрийн өмч нь ялсан намын шагналын касс, урамшууллын талбар болдгийг мэргэжлийн хүмүүс хэлдэг юм. [ЗГМ]

“Номин Холдинг” ХХК-ийн Ерөнхийлөгч Ш.Баярсайхан өвлийн олимпын бамбарыг буухиалсан анхны Монгол хүн боллоо



Хүн төрөлхтний эв нэгдлийн бэлгэ тэмдэг болсон өвлийн олимп тун удахгүй эхлэх гэж байна. БНСУ-д болох “Пёнчан-2018” өвлийн XXIII олимпын наадмын бамбар Өмнөд Солонгосын хотуудаар аялсаар байна. Хоёрдугаар сарын 9-нд нээлтээ хийх өвлийн олимпын бамбар буухиалах арга хэмжээнд оролцсон “Номин Холдинг” ХХК-ийн Ерөнхийлөгч Ш.Баярсайхан өвлийн олимпын бамбарыг буухиалсан анхны Монгол хүн боллоо.

Түүний олимпын галт бамбар буухиалан явахдаа хэлсэн үгийг та бүхэнд хүргэж байна. “Энэхүү арга хэмжээнд оролцох болсондоо туйлын их баяртай байна. Олимпын бамбар эртний Грекээс ирсэн. Солонгос улсад 101 өдөр аялах бөгөөд 9 муж, 8 том хотоор дамжин явсан. Манай сүлжээ дэлгүүрүүдээр сар бүр үйлчлүүлдэг 1.2 сая гаруй хэрэглэгч, гадаад, дотоодын нийт 10,000 заруй харилцагч, “Номин Холдинг” ХХК-ийн 5000 ажилтандаа баярлалаа, энэ боломжийг олгосон “Кока Колда”-ын хамт олонд болон аав ээж, гэр бүлийнхэндээ баярлалаа. Ирэх жилдээ Монгол хүн бүр амжилттай байхыг хүсэн ерөөе. Монголчууд мандууцай хурай” хэмээжээ.

“Пёнчан 2018” өвлийн олимпын бамбар Грекээс 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж аялсан бөгөөд Инчоны нисэх онгоцны буудлаас Чэжү аралд хүрч, улмаар Пусанд очин, цааш буухиалсаар байна.

Олимпын бамбар БНСУ-ын хотуудаар дамжин аялсаар 2 дугаар сарын 9-ний өдөр олимпын тосгонд очих юм. Олимпын бамбарыг “SAMSUNG”-ын Ноён Ким “Номин Холдинг” ХХК-ийн Ерөнхийлөгч Ш.Баярсайханд шилжүүлсэн бол тэрээр “Алтан Жолоо” Группийн Ерөнхийлөгч В.Энхбаатарт дамжуулсан байна.

Монголынхоо нийт баг тамирчдад амжилт хусье.

ТӨНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Бүрхүүлтэй электрод сонгон шалгаруулах тендер.
Тендер шалгаруулалтын дугаар: МС-2018/027
“ДЦС-4” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос “Бүрхүүлтэй электрод” нийлүүлэгчийн тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 50.000 /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн жил бүрийн борлуулалтын орлого нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. /2016,2017 он/

2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.

3. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын туршлага: Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 онуудын жилийн дүн нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн байна.

Тендерийн хамт 5,100,000 /Лаван сая нэг зуун мянган / төгрөгийн үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө.

Тендерийг 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 10.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 02 дугаар сарын 21 ний өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Монгол улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж,
“ДЦС-4” ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар310 тоот өрөө
Худалдан авах ажиллагааны хэлтэс
Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс 7018-1309 7000-1357

ТӨНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Өрлөг дулаалтын материал сонгон шалгаруулах тендер.
Тендер шалгаруулалтын дугаар: МС-2018/029
“ДЦС-4” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос “Өрлөг дулаалтын материал” нийлүүлэгчийн тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 50.000 /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн жил бүрийн борлуулалтын орлого нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. /2016,2017 он/

2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.

3. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын туршлага: Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 онуудын жилийн дүн нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн байна.

Тендерийн хамт 5,300,000 /Таван сая гурван зуун мянган / төгрөгийн үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө.

Тендерийг 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 10.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 02 дугаар сарын 21 ний өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Монгол улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж,
“ДЦС-4” ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар 310 тоот өрөө
Худалдан авах ажиллагааны хэлтэс
Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс 7018-1309 7000-1357